



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Чандмань бадрал ОНӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/5/СТА/ОНӨААН

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд сум

2020 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: [ariunaach@audit.gov.mn](mailto:ariunaach@audit.gov.mn)

**Аудитын менежер: Э.Энхцэцэг**

Утас: 90077079 Цахим хаяг: [enkhtsetsege@audit.gov.mn](mailto:enkhtsetsege@audit.gov.mn)

**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК**

Утас: 99108763 Цахим хаяг: [uwaauul.audit@gmail.com](mailto:uwaauul.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго үйл ажиллагаа .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Бизнес төлөвлөгөөний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	16
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	16
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	18
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	19
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	22

### Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## 1. Аудитын гэрчилгээ

 <b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	<b>ЧАНДМАНЬ БАДРАЛ ОНӨХХК-НИЙ ЗАХИРАЛ У.САНРАЙЖАВ ТАНАА</b>
2020.04.28 № 1-6/186 танай _____-ны № _____-т	
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чандмань бадрал ОНӨХХК-ний 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
<b>Зөрчилгүй санал дүгнэлт</b>	
<p>Чандмань бадрал ОНӨХХК-ний 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Чандмань бадрал ОНӨХХК-ний 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Чандмань бадрал ОНӨХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Чандмань бадрал ОНӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал У.Санрайжав Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чандмань бадрал ОНӨХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Чандмань бадрал ОНӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 2-наас 2020 оны 2 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 3-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Чандмань бадрал ОНӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг “Уваа уул аудит” ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 1/52 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Чандмань Бадрал ОНӨХХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь байгальд ээлтэй дэвшилтэт технологиор ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, хөгжилд тэмүүлсэн манлайлагч байгууллага болоход оршино.

Чандмань Бадрал ОНӨХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан хангамж
- Ус хангамж, ариутгах татуурга
- Инженерийн шугам сүлжээний засвар, үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

2019 онд НБББББ-ийг шинэчлэн батлуулж, мөрдөн ажиллаж байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Чандмань Бадрал ОНӨХХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Чандмань Бадрал ОНӨХХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “VINNICA 3.5.3” программ хангамж ашигладаг байна.

Чандмань-Бадрал ОНӨХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Чандмань Бадрал ОНӨХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,753,931.5 мянган төгрөгөөс тооцон 37,539.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 37,539.3 мянган төгрөгөөр тооцсон нь өөрчлөгдөөгүй байна.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Чандмань-Бадрал ОНӨХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,365.0 мянган төгрөгөөр буюу 1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	603,673.8	712,537.8	108,864.0
Авлага	553,904.2	515,808.1	-38,096.1
Урьдчилгаа	6,372.4	17,778.2	11,405.8
Бараа материал	198,801.6	266,683.5	67,881.9
Үндсэн хөрөнгө	1,717,032.6	1,606,652.9	-110,379.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,118,915.5</b>	<b>3,155,280.6</b>	<b>36,365.1</b>
Өр төлбөр	278,404.9	43,241.2	-235,163.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	846,529.9	846,529.9	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,118,915.5</b>	<b>3,155,280.6</b>	<b>36,365.1</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь борлуулалтын хэсэгт авлага барагдуулах арга хэмжээ зохион явуулснаар борлуулалтын байцаагч нар өөрсдийн хариуцсан айл өрх болон аж ахуйн нэгж байгууллагуудын авлагыг барагдуулах тал дээр анхаарч ажиллаж, 38,096.1 мянган төгрөгөөр буурсан үр дүн гарчээ. Авлага дансны үлдэгдэлд 2014-2017 онуудад үүссэн, хуулийн байгууллагаар шалгагдаж байгаа шалтгааны улмаас барагдах боломжгүй, эрсдэлтэй 17,786.2 мянган төгрөгийн авлага байгаагаас 14,468.6 мянган төгрөгийн авлага нь байгууллагаас авах, 3,317.6 мянган төгрөгийн авлага хувь хүнээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь Дорноговь аймгийн ЗДТГ-ын дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтын зөвлөмжийн дагуу шууд зардалд хийж байсан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийн /насос, мотор, инвертер, димесос/ хадгалалт, хамгаалалтыг сайжруулах үүднээс шууд зардалд бичдэг байсныг больж, дээрх бараа материалыг хангамжийн дансанд бүртгэн, картлуулж ажилласан байна. Үүнтэй холбоотойгоор 67,881.9 мянган төгрөгөөр бараа материалын үлдэгдэл өссөн харагдаж байна. 2019 оны нийт бараа материалын үлдэгдэл 266,683.5 мянган төгрөг байна. Үүнээс: Хангамж данс /БҮТЭЗ/ 117,994.5 мянган төгрөг, нүүрс 50,649.9 мянган төгрөг, дуусаагүй үйлдвэрлэл 1,317.6 /Ус түгээх байр барьж байгаа/, сантехникийн тоног төхөөрөмж 76,483.0 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 3,243.8 мянган төгрөг, бичиг хэрэг 1,475.5 мянган төгрөг, хөдөлмөрийн аюулгүй байдлын 4,258.7 мянган төгрөг, шатахуун 2,178.9 мянган төгрөг, тусгай зориулалттай бараа материал 668.9 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна. Ашиглагдахгүй, он удаан жил болсон бараа материалын үлдэгдэл байхгүй.

Бараа материалын данснаас 2019 оны хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн ЭҮ-1 блокон хашаа, гражийн барилга, автын зөөврийн сууц зэрэг 58,565.7 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд бүртгэж авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тухайн жилд байгуулсан элэгдлийн хэмжээгээр буурсан нь шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар хийгдсэн 119,020,6 мянган төгрөгийн хөрөнгө байна. Хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө байхгүй байна.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн болон акталсан үндсэн хөрөнгө байхгүй байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь байгуулсан элэгдлийн хэмжээгээр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 235,163.7 мянган төгрөгөөр буурсан. 2019 оны эцсээр татвар болон нийгмийн даатгал, дотоодын байгууллагад 2,018.3 мянган төгрөг, урьдчилж орсон орлого 37,841.8 мянган төгрөг, ажилтан, албан хаагчдад өгөх өглөг 3,381.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Урьдчилж орсон орлогын дүн нь 2020 онд хийгдэх ажлуудын урьдчилгаа төлбөр байна. Ажилтан, албан хаагчдад өгөх өглөг нь ажлаас халагдсан, тооцоо хийгээгүй ажилчдын цалингийн өглөг байна.

Урт хугацаат өр төлбөр байхгүй. Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

## 2.9. Бизнес төлөвлөгөөний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга

Чандмань бадрал ОНӨХХК-ийн 2019 оны батлагдсан бизнес төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харууллаа.

### А. Орлогын төлөвлөгөөний биелэлт

Тайлант онд 3,664,122.2 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 3,753,821.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 102.4 хувиар биелүүлсэн байна.

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Ус хангамжийн орлого	619,349.0	470,855.1	-148,493.9	76.0
Дулааны орлого	2,502,558.3	2,422,659.1	-79,899.3	97.0
Ариутгах татуургын орлого	246,042.7	265,519.2	19,476.5	108.0
Суурь хураамж/ Ус хангамж/	64,872.2	78,515.2	13,642.8	121.0
Суурь хураамж /Дулаан/	69,300.0	88,437.0	19,137.0	128.0
Бусад орлого	162,000.0	427,836.0	265,836.0	264.0
<b>Нийт дүн</b>	<b>3,664,122.2</b>	<b>3,753,821.6</b>	<b>89,699.4</b>	<b>102.4</b>

Нийт борлуулалтын орлогыг авч үзвэл Ус хангамжийн орлого төвлөрүүлэлт 24.0 хувиар тасарсан. Шалтгаан нь:

- 2018 онд Замын-Үүдийн төмөр замын ложистикийн барилга байгууламжийн ажил хийгдэж, усны хэрэглээ нэмэгдэн, орлого өсч байсан боловч уг байгууламж нь 2019 оны хагас жилээр ашиглалтанд орж, усны хэрэглээ эрс багассан нь орлого буурахад голлон нөлөөлсөн байна

- Чандмань бадрал ОНӨХХК “Бидний ус-чандмань эрдэнэ” нэртэй усны хэрэглээг таниулсан өдөрлөгийг жил бүр ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлан явуулдагийн үр дүнд нийт хэрэглэгчид усаа ариг гамтай хэрэглэдэг болж, усны борлуулалтын хэмжээ буурч байгаа нь үүнд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа гэж компани үзэж байгаа юм байна.

Ус хангамжаас бусад орлогын нэр төрлийн төлөвлөгөө биелсэн байна. Тухайлбал: Бусад орлого 264 хувиар даван биелсэн нь 2019 онд гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн цэвэр усанд холбох ажил хийгдэж, уг ажлын хүрээнд 1837 метр цэвэр усны шугам татаж, 87 өрхийг цэвэр устай холбосон нь нөлөөлсөн байна.

#### Б. Зардлын төлөвлөгөөний биелэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	2019 оны төлөвлөгөө		Зөрүү	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тоо	Хувь
<b>Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал</b>	1,104,758.4	1,322,518.0	217,759.6	119.7
<b>Байгууллагаас төлөх ЭМ, НДШ</b>	160,190.0	191,765.1	31,575.1	119.7
<b>ТУЗ цалин</b>	19,064.3	13,045.1	(6,019.2)	68.4
<b>Түлшний зардал</b>	695,398	689,197.9	(6,200.1)	99.1
<b>Худалдаж авах-Цахилгаан</b>	212,892	246,311.9	33,419.5	115.7
<b>Дотоод хэрэглээ цэвэр ус</b>	4,632	8,890.0	4,258.0	191.9
<b>Дотоод хэрэглээ дулаан</b>	7,800	2,240.0	(5,560.0)	28.7
<b>Шатахууны зардал</b>	77,941	68,652.9	(9,288.3)	88.1
<b>Их засвар</b>	58,454	29,156.7	(29,296.8)	49.9
<b>Урсгал засвар</b>	123,401	86,460.0	(36,941.0)	70.1
<b>Материал, хангамжийн материал</b>	66,680	84,443.2	17,763.2	126.6
<b>Сэлбэг хэрэгсэл</b>	16,249.2	31,469.0	15,219.8	193.7
<b>Хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал</b>	58,309	41,067.2	(17,242.2)	70.4
<b>Албан томилолтын зардал</b>	32,902	27,367.5	(5,534.5)	83.2
<b>Сургалтын зардал</b>	17,980	6,185.7	(11,794.3)	34.4
<b>Бичиг хэргийн зардал</b>	5,922	6,832.8	910.8	115.4
<b>Харилцаа холбооны зардал</b>	2,910	7,162.7	4,252.7	246.1
<b>Зохицуулалтын үйлчилгээний хөлс</b>	9,480	8,405.0	(1,075.0)	88.7
<b>Тээврийн зардал</b>	12,000	2,000.0	(10,000.0)	16.7
<b>Захиалгат ажлын зардал</b>	26,480	113,765.6	87,285.6	429.6

<b>Засвар үйлчилгээний зардал</b>		23,456.0	10,856.0	186.2
	12,600			
<b>Байгаль орчин хамгаалах зардал</b>		20,000.0	(8,000.0)	71.4
	28,000			
<b>Зар сурталчилгааны зардал</b>		552.6	(1,447.4)	27.6
	2,000			
<b>Гадаад үйлчилгээний зардал</b>		5,405.8	(12,406.2)	30.3
	17,812			
<b>Бусад зардал</b>		78,987.4	18,488.4	130.6
	60,499			
<b>Үйл ажиллагааны зардал</b>		<b>3,115,338</b>	<b>280,983.9</b>	109.9
	<b>2,834,354</b>			
<b>Элэгдлийн зардлын дүн</b>		225,375.5	102,283.1	183.1
	123,092			
<b>Орлогын албан татвараас бусад татвар</b>		8,868.0	(2,251.0)	79.8
	11,119			
<b>Бүрэн өөрийн өртөг</b>			381,016.0	112.8
	2,968,566	3,349,582		
<b>Ажиллагсдын нийгмийн зардал</b>		166,848.5	(76,290.6)	68.6
	243,139			
<b>Хөрөнгө оруулалт</b>		-	(351,416.8)	0.0
	351,417			
<b>Нийт зардал</b>		<b>3,516,430</b>	<b>(46,691.4)</b>	98.7
	<b>3,563,121</b>			

#### Зардал өссөн шалтгаанууд:

Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал - ТУЗ-ийн 2019 оны 03 дугаар тогтоолоор удирдлага-5 хувь, захиргаа, аж ахуй-7 хувь, үйлдвэр хувиар нэмсэн. 9 дүгээр сард ТУЗ -ийн 2019 оны 08 дугаар тогтоолоор үндсэн цалинг бүх ажилтанд ижил 80,000 төгрөгөөр нэмсэн байна.

Цахилгааны тариф 145.35 төгрөгөөс 154.35 төгрөг, дэмжих тариф 1квт нь 4 төгрөг байснаа 23 төгрөг 49 мөнгө болж нэмэгдсэн.

Зуухнаас гарч байгаа сүлжээний усыг төлөвлөөгүй байсан байна. Тиймээс Дотоод хэрэглээ цэвэр усны зардал хэтэрсэн харагдаж байна.

Юаний ханшийн зөрүүнээс болж, бараа материалын үнэ өртөг нэмэгдсэн.

Сэлбэг хэрэгсэл -Гэнэтийн эвдрэл гэмтэл гарсан. 56-47 УН экскаваторын мотор шатаж, 6,185.0 мянган төгрөгийн мотор авсан. 24-74 УН экскаваторын гидрийн насос нь эвдэрч 3,159.0 мянган төгрөгөөр авч суурилуулсан. 32-18 фургоны коробка нь цоорсон тул 3,112.0 мянган төгрөгийн төлөвлөгдөөгүй зардал гарчээ.

Харилцаа холбооны зардал - Интернетийн төлбөрийг гадаад үйлчилгээний хөлсөнд төлөвлөснийг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсаны дагуу харилцаа холбооны зардалд бүртгэсэнээр хэтэрсэн харагдаж байна.

Засвар үйлчилгээний зардал - Цахилгааны өргөтгөлийн засварын ажил 4,058.0 мянган төгрөг, ус түгээх байрнуудын засварын ажил 2,855.0 мянган төгрөг, шинээр нүүрс буулгах зам засварласны 1,693.0 мянган төгрөг, борлуулалтын өрөөний засвар 2,250.0 мянган төгрөгний зардал тус тус гарсан. Эдгээр зардлуудыг төлөвлөөгүй байжээ.

Захиалгат ажлын зардал- 2019 онд гэр хороололд нийт 88 айл өрхөд 3000 метр цэвэр усны шугам холбож өгсөн. 1метрийг нь 31500 төгрөгөөр техникийн нөхцлийн дагуу тавьдаг. Энэхүү үнэд машин механизм, материал, ажиллах хүчний зардал орсон болно. 2019 онд хичнээн айл өрх, ААНБ шинээр цэвэр ус холбуулах нь тодорхой бус байдаг болохоор энэхүү зардал нь хэтэрсэн байна.

Элэгдлийн зардлын дүн- Үндсэн хөрөнгө нэмэгдсэн, мөн дахин үнэлгээгээр элэгдлийн зардал өссөн.

#### **Зардал буурсан шалтгаанууд:**

Үйлдвэрийн объектуудын дотоод дулааныг гүйцэтгэлээр бүртгээгүйгээс буурсан байна..

Тээврийн зардлыг бараа бүтээгдэхүүнд шингээж орлого авч байгаа учир гүйцэтгэл бага харагдаж байна.

#### **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл нэмж тодорхойлж, нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 12,367.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 12,367.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

#### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

2018 онд цөөн хэдэн сар захирлаар ажилласан Буянбадрахын үед DZL маркийн зуух худалдан авах, тээвэрлэх, суурилуулах болон ашиглалт, засвар үйлчилгээтэй холбоотой 189,711.0 мянган төгрөгийн зардал гарсан. Эвдрэл гэмтэл их гарч, засварын зардал их гарсан, цахилгааны зардал өссөн байна. Энэ талаар 2018 оны санхүүгийн тайлангийн аудитад дурдаагүй байна. 2019 онд Авилгатай тэмцэх газраас уг асуудлын талаар шалгаж байна. Мөн 2019 онд 40,818.7 мянган төгрөгийн материал, урсгал засварын зардал нэмж гарсан байна. Иймд 2018 онд худалдан авсан DZL маркийн зууханд 2020 онд нэмж зардал гарсан эсэх талаар анхаарч үзнэ.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Чандмань бадрал ОНӨХХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 51 мэдээллийг хугацаанд нь, 92 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

Хугацаа хоцроосон талаар компаниас дараах тайлбар өгөв. Үүнд:

-Хоцроосон мэдээлэлд манай байгууллагын шилэн данс мэдээлэх хэсэгт байгаагүй 6 мэдээллийг 9 дүгээр сарын 30-нд нэмж оруулан, нөхөж хийлгүүлсэн 48 мэдээллийг хугацаа хоцроосонд тооцсон.

-Хугацаандаа явуулсан боловч ахин орж засварласан нь 24 мэдээллийг мөн адил хугацаа хоцорсон гэж тооцсон.

Харин 20 мэдээлэл хугацаа хоцорсон.

#### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7,362.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 567.4 мянган төгрөгийг барагдуулсан, 19,997.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснээс 453.8 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. 7 зөвлөмж өгснөөс 7 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Чандмань бадрал ОНӨХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 12,367.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 37,539.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

“Зөрчилгүй” дүгнэлт

Чандмань бадрал ОНӨХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл, тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1. Авлага данстай холбоотой асуудал

##### 3.1.1. Илрүүлэлт:

Хэрэглэгчидтэй тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

##### 3.1.2. Эрсдэл:

Авлага буруу илэрхийлэгдэх

##### 3.1.2 Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх.

##### 3.1.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөрчлийг хүлээн зөвшөөрөв.

#### 3.2. Худалдан авалт болон гэрээний хэрэгжилт, биелэлттэй холбоотой асуудал

##### 3.2.1 Илрүүлэлт:

Чандмань бадрах ОНӨХХК-ийн захирлын 2019 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн А/93 тушаалд "695,398,000 төгрөгөөр нүүрс худалдан авах гэрээг Шивээ Овоо ХК-тай байгуулахыг эдийн засагчид зөвшөөрсүгэй" гэсэн нь Шивээ Овоо ХК-иас ирүүлсэн үнийн санал болон Тендерийн үнэлгээний хорооны тайланд тусгасан үнийн дүнгээс 2,300.5 мянган төгрөгөөр илүү буюу Худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнд суулгасан дүнгээр бичсэн байна.

##### 3.2.2 Эрсдэл:

Гэрээний дүн илүү тусгагдах.

**3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх.

**3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөрчлийг хүлээн зөвшөөрөв.

**3.3 Худалдан авалт болон гэрээний хэрэгжилт, биелэлттэй холбоотой асуудал**

**3.3.1 Илрүүлэлт:**

2019 оны 8 дугаар сарын 31-нд тендер зарлаж, 10 дугаар сарын 2-нд тендер нээсэн. Гэрээ байгуулах мэдэгдэл болон гэрээ байгуулах тухай тушаалууд 10 дугаар сарын 7-ноор огноологдсон боловч гэрээ байгуулсан огноо 9 дүгээр сарын 1 гэсэн байна. Гэрээний 6.3 "Бусад нөхцөл" гэсэн хэсэгт үргэлжлэх хугацааг 2019 оны 9 дүгээр сарын 1-нээс 2020 оны 9 дүгээр сарын 1 хүртэл байна гэсэн боловч хавсралтанд 2019 оны 10 дугаар сараас 2020 оны 4 дүгээр саруудад нүүрс нийлүүлэх хуваарь хийжээ. Эдгээр нь цаг хугацааны хувьд зөрчилтэй байна.

**3.3.2 Эрсдэл:**

Гэрээ хүчин төгөлдөр бус болох.

**3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх.

**3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөрчлийг хүлээн зөвшөөрөв.

**3.4. Худалдан авалт болон гэрээний хэрэгжилт, биелэлттэй холбоотой асуудал**

**3.4.1 Илрүүлэлт:**

Уурын зуухны ул ширэм худалдан авах тухай Чандмань бадрах ОНӨААТҮГ-ын захирлын 2019.5.20-ны А/51 тушаалд гэрээ байгуулах этгээдийн нэрийг заагаагүй байна.

**3.4.2 Эрсдэл:**

Гэрээ хүчин төгөлдөр бус болох.

**3.4.3 Өгсөн зөвлөмж:**

Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх.

**3.3.5 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөрчлийг хүлээн зөвшөөрөв.

**3.5. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал**

**3.5.1 Илрүүлэлт:**

"0" үлдэгдэлтэй үндсэн хөрөнгүүд ашиглагдаж байна. Үүнд : барилга байгууламж - 8, машин, тоног төхөөрөмж - 6, тээврийн хэрэгсэл - 1, компьютер тоног төхөөрөмж - 4, программ хангамж - 6 ширхэг байна.

**3.5.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

**3.5.3 Өгсөн зөвлөмж:**

ТӨБЗГ-ын 2019 оны 271 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах .

**3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөрчлийг хүлээн зөвшөөрөв.

**3.6 Урьдчилж төлсөн зардал данстай холбоотой асуудал**

**3.6.1 Илрүүлэлт:**

"Дуусаагүй үйлдвэрлэл" 1410 дансанд хуримтлуулан бүртгэгдэх зардлуудыг "Урьдчилж төлсөн зардал" 1301 дансанд бүртгэсэн байна.

**3.6.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

**3.6.3 Өгсөн зөвлөмж:**

Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх.

**3.6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

"Дуусаагүй үйлдвэрлэл" дансанд бүртгэхээр "Үндсэн хөрөнгө" дансанд орлого авагдахгүй, программ алдаа заагаад байсан гэсэн тайлбар хийж байна. 2020 онд "Ординат" ХХК программын тохируулга хийж өгнө гэсэн.

**3.7 Борлуулалтын орлого данстай холбоотой асуудал**

**3.7.1 Илрүүлэлт:**

Борлуулалтын орлогын дэд дансдын хооронд зарим тохиолдолд гүйлгэн бүртгэсэн байна. Тухайлбал: "Бусад борлуулалт" 5105 дэд дансанд "Туслах үйл ажиллагаа" /захиалгат ажил/ 5101, "Борлуулалтын хорогдол, буцаалт" 5201 дэд дансанд "Борлуулалтын хөнгөлөлт" 5205 дэд дансанд бүртгэгдэх орлого тус тус бүртгэгдсэн байна.

**3.7.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

**3.7.3 Өгсөн зөвлөмж:**

Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх.

3.7.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөрчлийг хүлээн зөвшөөрөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,401,882,998.20</u></b>	<b><u>1,548,627,634.32</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b><u>603,673,872.99</u></b>	<b><u>712,537,806.58</u></b>
<b>311</b>	Кассанд байгаа бэлэн мөнгө	<b><u>595,856,927.78</u></b>	<b><u>712,537,806.58</u></b>
<b>31110</b>	Төгрөг	<b><u>7,362,408.60</u></b>	<b>-</b>
<b>31140</b>	Касс арилжааны банк	588,494,519.18	712,537,806.58
<b>31223</b>	Арилжааны банк дахь харилцах	7,816,945.21	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	593,035,046.05	551,628,066.17
<b>33401</b>	Дансны авлага /ТӨҮГ/	553,904,213.61	515,808,091.27
<b>33402</b>	Татвар, НДШ – ийн авлага /ОНӨ/	18,790,545.47	8,669,979.57
<b>335</b>	Бусад авлага	20,340,286.97	27,149,995.33
<b>3352</b>	Хувь хүмүүсээс авах авлага	20,340,286.97	27,149,995.33
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	6,372,430.85	17,778,205.62
<b>34600</b>	Урьдчилж гарсан зардал	6,372,430.85	17,778,205.62
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	198,801,648.31	266,683,555.95
<b>351</b>	Түүхий эд материал	668,973.00	668,973.00
<b>35110</b>	Тусгай зориулалттай материал	668,973.00	668,973.00
<b>35200</b>	Дуусаагүй үйлдвэрлэл	6,896,793.05	1,317,646.73
<b>354</b>	Хангамжийн материал	191,235,882.26	264,696,936.22
<b>35410</b>	Бичиг хэргийн материал	1,848,549.95	1,475,534.11
<b>35430</b>	Сэлбэг хэрэгсэл	7,967,234.26	3,243,832.62
<b>35440</b>	Түлш, шатах тослох материал	45,167,016.50	52,828,957.49
<b>35450</b>	Барилгын засварын материал	11,434,341.13	8,412,261.10
<b>35470</b>	Бусад хангамжийн материал	124,818,740.42	198,736,350.90
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,717,032,555.99</b>	<b>1,606,652,962.88</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,717,032,555.99</b>	<b>1,606,652,962.88</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,710,691,306.94</b>	<b>1,604,695,938.54</b>
<b>39201</b>	Барилга, байгууламж, орон сууц	1,162,210,521.40	1,212,569,021.97
<b>39202</b>	Хуримтлагдсан элэгдэл	(143,378,105.04)	(269,990,534.37)
<b>39203</b>	Авто-тээврийн хэрэгсэл	370,916,446.00	399,964,206.00
<b>39204</b>	Хуримтлагдсан элэгдэл	(134,260,225.95)	(162,202,231.69)
<b>39205</b>	Машин тоног төхөөрөмж (компьютер)	612,381,327.24	638,671,692.25
<b>39206</b>	Хуримтлагдсан элэгдэл	(182,872,237.33)	(242,988,243.62)
<b>39207</b>	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,647,167.31	28,103,477.02
<b>39208</b>	Хуримтлагдсан элэгдэл	(22,953,586.69)	(11,990,054.24)
<b>39214</b>	Бусад үндсэн хөрөнгө	-	35,828,124.57
<b>39215</b>	Хуримтлагдсан элэгдэл	-	(23,269,519.35)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>6,341,249.05</b>	<b>1,957,024.34</b>
<b>39301</b>	Програм хангамж	18,838,660.00	19,088,660.00
<b>39302</b>	Хуримтлагдсан элэгдэл	(12,497,410.95)	(17,131,635.66)

3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	3,118,915,554.19	3,155,280,597.20
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	278,404,903.13	43,241,245.34
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	278,404,903.13	43,241,245.34
413	<b>Өглөг</b>	206,641,218.73	5,399,368.93
41310	<b>Ажилчидтай холбогдсон өглөг</b>	3,238,927.00	3,381,076.02
4136	<b>Бусад өглөг</b>	203,402,291.73	2,018,292.91
41363	<b>Татварын өглөг /ОНӨ/</b>	69,467,190.94	651,327.67
41364	<b>НДШ - ийн өглөг /ОНӨ/</b>	-	989,865.24
41366	<b>Дансны өглөг /ОНӨ/</b>	133,935,100.79	377,100.00
414	<b>Урьдчилж орсон орлого</b>	71763684.40	37,841,876.41
41440	<b>Бусад урьдчилж орсон орлого</b>	71,763,684.40	37,841,876.41
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	2,840,510,651.06	3,112,039,351.86
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,840,510,651.06	3,112,039,351.86
511	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	1,008,380,959.50	1,008,380,959.50
51101	<b>Өмч: - төрийн</b>	846,529,959.90	846,529,959.90
51106	<b>Эздийн өмчийн бусад хэсэг</b>	161,850,999.60	161,850,999.60
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,077,575,574.76	1,349,104,275.56
51210	<b>Өмнөх үеийн үр дүн</b>	1,077,575,574.76	1,111,713,206.56
51220	<b>Тайлант үеийн үр дүн</b>	-	237,391,069.00
51300	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	754,554,116.80	754,554,116.80
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	3,118,915,554.19	3,155,280,597.20

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,599,494,557.86	3,753,821,639.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,052,107.61	22,608,874.93
120	Нийтлэг татварын бус орлого	27,052,107.61	22,608,874.93
120002	Хүүгийн орлого	27,052,107.61	22,608,874.93
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,094,563,693.10	2,790,903,990.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,094,563,693.10	2,790,903,990.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	834,215,390.56	1,110,250,062.75
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	834,215,390.56	1,110,250,062.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,737,309.75	160,507,697.97
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	128,737,309.75	160,507,697.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	176,221,486.91	245,069,672.95
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	176,221,486.91	245,069,672.95
2104	Хангамж, бараа материалын зардал	1,324,938,079.64	553,139,405.57
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	848,690,631.50	491,266,608.80
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	476,247,448.14	61,872,796.77
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	630,451,426.24	721,937,151.68
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	-	130,628,457.94
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	169,997,531.04	414,337,950.90
210813	Бусад зардал /ТӨҮГ/	424,203,901.84	176,970,742.84
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	36,249,993.36	26,376,785.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	504,930,864.76	962,917,648.18
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		109,885.13
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		109,885.13
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	30,790.14	68,597.89
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	30,790.14	68,597.89
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(30,790.14)	41,287.24
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	504,900,074.62	962,958,935.42

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,887,968,018.49	4,217,094,010.86
120002	Хүүгийн орлого	32,209,341.05	20,382,524.71
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,887,968,018.49	4,217,094,010.86
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,603,562,679.14	4,149,057,431.74
120009	Бусад орлого	284,405,339.35	68,036,579.12
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,914,171,357.24	4,108,736,701.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,914,171,357.24	4,108,736,701.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,017,608,336.43	1,178,038,200.10
210101	Үндсэн цалин	1,017,608,336.43	1,178,038,200.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	314,641,506.15	374,867,931.16
210201	Тэтгэврийн даатгал	314,641,506.15	374,867,931.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	188,966,009.61	210,313,192.18
210301	Гэрэл, цахилгаан	188,966,009.61	210,313,192.18
2104	Хангамж, бараа материалын зардал	335,794,256.51	923,748,365.00
210402	Тээвэр, шатахуун	335,794,256.51	923,748,365.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	818,111,213.99	857,932,344.16
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	405,405,112.80	511,122,553.66
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	2,569,536.00	1,900,400.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	410,136,565.19	344,909,390.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,239,050,034.55	563,836,669.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,239,050,034.55	563,836,669.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(26,203,338.75)	108,357,308.88
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	33,209,341.05	20,382,524.71
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1,000,000.00	
140007	Хүлээн авсан хүүний орлого	32,209,341.05	20,382,524.71
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	19,875,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	19,875,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	19,875,900.00
222001	Тоног төхөөрөмж	-	19,875,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	33,209,341.05	506,624.71
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	7,006,002.30	108,863,933.59
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	596,667,870.69	603,673,872.99
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	603,673,872.99	712,537,806.58

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	846,529,959.90	754,554,116.80	1,077,575,574.76	161,850,999.60	2,840,510,651.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00		0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>846,529,959.90</b>	<b>754,554,116.80</b>	<b>1,077,575,574.76</b>	<b>161,850,999.60</b>	2,840,510,651.06
Тайлант үеийн үр дүн			0.00		0.00
<b>2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	846,529,959.90	754,554,116.80	1,077,575,574.76	161,850,999.60	2,840,510,651.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			34,137,631.80		34,137,631.80
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>846,529,959.90</b>	<b>754,554,116.80</b>	<b>1,111,713,206.56</b>	<b>161,850,999.60</b>	2,874,648,282.86
Тайлант үеийн үр дүн			237,391,069.00		237,391,069.00
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	846,529,959.90	754,554,116.80	1,349,104,275.56	161,850,999.60	3,112,039,351.86

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<b>Чандмань-Бадрал ОНӨХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2019.12.31			ДГА-2020/5/СТА-ОНӨААН
Шалгагдсан байгууллагын нэр:	Чандмань-Бадрал ОНӨХХК		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	"0" үлдэгдэлтэй үндсэн хөрөнгүүд ашиглагдаж байна. Үүнд : барилга байгууламж -8, машин, тоног төхөөрөмж -6, тээврийн хэрэгсэл -1, компьютер тоног төхөөрөмж -4, программ хангамж 6 ширхэг байна.	-	ТӨБЗГ-ын 2019 оны 271 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах	Захирал нябо	У.Санрайжав Ц.Лхагвасүрэн
2	Чандмань бадрах ОНӨААТҮГ-ын захирлын 2019.10.7-ны А/93 тушаалд " 695,398,000 төгрөгөөр нүүрс худалдан авах гэрээг Шивээ Овоо ХК-тай байгуулахыг эдийн засагчид зөвшөөрсүгэй" гэсэн нь Шивээ Овоо ХК-иас ирүүлсэн үнийн санал болон Тендерийн үнэлгээний хорооны тайланд тусгасан үнийн дүнгээс 2,300,500 төгрөгөөр илүү байна.	2,300.50	Зөрчлийг таслан зогсоох	Захирал нябо	У.Санрайжав Ц.Лхагвасүрэн
3	8 дүгээр сарын 31-нд тендер зарлаж, 10 дугаар сарын 2-нд тендер нээсэн. Гэрээ байгуулах мэдэгдэл болон гэрээ байгуулах тухай тушаалууд 10 дугаар сарын 7-ноор огноологдсон боловч гэрээ байгуулсан огноо 9 дүгээр сарын 1 гэсэн байна. Гэрээний 6.3	-	Зөрчлийг таслан зогсоох	Захирал нябо	У.Санрайжав Ц.Лхагвасүрэн

	"Бусад нөхцөл" гэсэн хэсэгт үргэлжлэх хугацааг 2019 оны 09 дүгээр сарын 1-нээс 2020 оны 9 дүгээр сарын 1 хүртэл байна гэсэн боловч хавсралтанд 2019 оны 10 дугаар сараас 2020 оны 4 дүгээр саруудад нүүрс нийлүүлэх хуваарь хийжээ. Эдгээр нь цаг хугацааны хувьд зөрчилтэй байна.				
4	Уурын зуухны ул ширэм худалдан авах тухай Чандмань бадрах ОНӨААТҮГ-ын захирлын 2019.5.20-ны А/51 тушаалд гэрээ байгуулах этгээдийн нэрийг заагаагүй байна.	-	Зөрчлийг таслан зогсоох	Захирал нябо	У.Санрайжав Ц.Лхагвасүрэн
5	Борлуулалтын орлогын дэд дансдын хооронд зарим тохиолдолд гүйлгэн бүртгэсэн байна. Тухайлбал:" Бусад борлуулалт" 5105 дэд дансанд "Туслах үйл ажиллагаа" /захиалгат ажил/ 5101, "Борлуулалтын хорогдол, буцаалт" 5201 дэд дансанд "Борлуулалтын хөнгөлөлт" 5205 дэд дансанд бүртгэгдэх орлого тус тус бүртгэгдсэн байна.	-	Зөрчлийг таслан зогсоох	Захирал нябо	У.Санрайжав Ц.Лхагвасүрэн
6	"Дуусаагүй үйлдвэрлэл" 1410 дансанд хуримтлуулан бүртгэгдэх зардлуудыг "Урьдчилж төлсөн зардал" 1301 дансанд бүртгэсэн байна. Дуусаагүй үйлдвэрлэл" дансанд бүртгэхээр "Үндсэн хөрөнгө" дансанд орлого авагдахгүй программ алдаа заагаад байсан гэсэн тайлбар хийж байна.	-	Зөрчлийг таслан зогсоох	Захирал нябо	У.Санрайжав Ц.Лхагвасүрэн
7	13 хэрэглэгчидтэй тооцоо нийлж,	10,066.60	Зөрчлийг таслан зогсоох	Захирал нябо	У.Санрайжав Ц.Лхагвасүрэн

	үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.				
	ДҮН	<b>12,367.10</b>			